



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 11

Сүхбаатар сум

2024 оны 4 дүгээр улиралд хийсэн
санхүүгийн хяналт шалгалтын дүнгийн тухай

Төсвийн тухай хуулийн 69.3, Монгол улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.7, Сангийн Сайдын 2019 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг ТОГТООХ нь:

Нэг. Монгол Улсын Сангийн Сайдын баталсан “Татварын Ерөнхий газар, түүний харьяа газар, газрын үйл ажиллагаанд хийх нэгдсэн хяналт шалгалтын удирдамж”-ийг үндэслэн Сэлэнгэ аймгийн Татварын газарт хийсэн хяналт шалгалтын үр дүн, Соёлын сайдтай байгуулсан аймгийн Засаг даргын гэрээнд тусгагдсан Соёлын сайдын баталсан хяналт шалгалтын нэгдсэн удирдамжаар Сэлэнгэ аймгийн Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын газар, Нийтийн номын сан, Нэгдсэн музей, Мөнгөн хараа чуулгын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын үр дүн, Баруунбүрэн, Ерөө, Сүхбаатар, Мандал, Хушаат, Жавхлант сумын ИТХ-ын ажлын алба болон ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн дүн, эрсдэлийн үнэлгээг хавсралтаар баталсугай.

Хоёр. Санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг тогтоосон хугацаанд бүрэн арилгах, арга хэмжээг авч хяналт шалгалтаар өгсөн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэн төсвийн сахилга бат, үр ашиг, үр нөлөө, ил тод байдлыг ханган эрсдэлийн үнэлгээг бууруулан ажиллахыг Төсвийн шууд захирагч нарт даалгасугай.


Гурав. Дотоод аудитын хорооны тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нарийн бичгийн дарга (Т.Мөнхзул)-д үүрэг болгосугай.

Хорооны дарга:  Н.Пхагвадорж
(Аймгийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга:  Т.Мөнхзул
(Ахлах дотоод аудитор)

Гишүүд:  Т.Одсүрэн
(Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга)


4324009011



Ө.Сувдаа
(Аймгийн Засаг даргын
Тамгын газрын дарга)



Х.Мөнхжаргал
(Санхүү төрийн сангийн хэлтсийн
дарга)



Б.Янжинлхам
(Хууль зүйн хэлтсийн дарга)



А.Дашбат
(Иргэний төлөөлөл)

А.Гэрэлмаа
(Иргэний төлөөлөл)

Дотоод аудитын хорооны 2024 оны 12 дугаар сарын 18-ны
өдрийн 1/1 дугаар тогтоолын хавсралт

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТАД ХАМРАГДСАН БАЙГУУЛЛАГЫН
ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ

д/д	Байгууллагын нэр	Илэрсэн зөрчлийн дүн	Эрсдэлийн үнэлгээ
1	Сэлэнгэ аймгийн Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын газар	91,397.1	"Их" эрсдэлтэй
2	Нийтийн номын сан	10,599.1	"Бага" эрсдэлтэй
3	Сэлэнгэ аймгийн Нэгдсэн музей	14,806.3	"Бага" эрсдэлтэй
4	Мандал сумын Мөнгөн хараа чуулга	30,105.2	"Дунд" эрсдэлтэй
5	Баруунбүрэн сумын ЗДТГ	34,545.4	"Дунд" эрсдэлтэй
6	Баруунбүрэн сумын ИТХ	19,399.8	"Дунд" эрсдэлтэй
7	Мандал сумын ЗДТГ	468,865.9	"Дунд" эрсдэлтэй
8	Мандал сумын ИТХ	90,817.2	"Дунд" эрсдэлтэй
9	Хушаат сумын ЗДТГ	119,456.1	"Дунд" эрсдэлтэй
10	Хушаат сумын ИТХ	47,228.2	"Дунд" эрсдэлтэй
11	Жавхлант сумын ЗДТГ	50,777.0	"Дунд" эрсдэлтэй
12	Жавхлант сумын ИТХ	15,166.3	"Дунд" эрсдэлтэй
13	Ерөө сумын ЗДТГ	173,014.1	"Дунд" эрсдэлтэй
14	Ерөө сумын ИТХ	14,560.6	"Дунд" эрсдэлтэй
	Дүн		